



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот
2025

АГУУЛГА

Нэг.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт нь тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх.....	3
Хоёр.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх	29
Гурав.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд заасан бүрэн хэрэгжээгүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийн шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаар.....	30
Дөрөв.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний санхүүжилтийн гүйцэтгэл	31
Дүгнэлт	33
Зөвлөмж	34

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрх зүйн үндэслэл: Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1.4, 117.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийсэн болно.

Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Тамгын газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор энэ хуулийн 17.2-т заасан бүрдлийг хянаж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл үндэслэл бүхий тайлбарын хамт Засгийн газарт мэдэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газраас тайлангийн бүрдлийг хянан үзэж, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, Төсвийн ерөнхийлөн захирагч /ТЕЗ/-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийг тайлагнах; төсөл, арга хэмжээг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.2.1-д заасны дагуу үнэлэх; бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж бүрдүүлбэрийг хангаж ирүүлэх тухай 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн ТГ-01/193 дугаар албан бичгийг явуулсан. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/197 дугаар албан бичгээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үнэлгээний танилцуулгыг ирүүлсэний дагуу дүн шинжилгээ хийлээ.

Зорилго: Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө нь тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний зорилтот түвшинд хүрсэн эсэх, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилт хангалтгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлд шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж хүргүүлэхэд чиглэгдсэн.

Арга зүй: 2024 оны дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийн түвшнийг үнэлэн тогтоохдоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалыг удирдлага болгосон.

Мэдээллийн эх сурвалж: Дүн шинжилгээг дараах тайлан, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”, “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”;
- “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайлан болон “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;
- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/197 дугаар албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үнэлгээний талаарх нэмэлт тодруулга мэдээлэл зэрэг болно.

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ ТУХАЙН ЖИЛИЙНХЭЭ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРСЭН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН ЭСЭХ

1.Экспортыг нэмэгдүүлнэ.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Экспортыг нэмэгдүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтээр экспортыг 13.7 тэрбум ам.долларт хүргэхээр зорилтот түвшнийг тогтоосон бөгөөд 2024 оны гүйцэтгэлээр экспорт 15.8 тэрбум ам.долларт хүрч , биелэлт 115.3 хувьтай байна. Энэ нь 2023 оны жилийн эцэст экспорт 15.2 тэрбум ам.доллар байсантай харьцуулахад 3.93%-ийн өсөлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд 4 ТЕЗ-ийн үр дүнг баталсан бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 1-д үзүүлэв:

Хүснэгт 1.ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл , хувь
1	1.1. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Ачаа эргэлт	Сая тонн/км	17572.7	26944.8	24500	73.91
2	1.2. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадал	Сая тонн	50	80	103.2	100.00
3	1.3. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт	Сая ам.доллар	380.6	506.6	391.9	8.97
4	1.4. Гадаад худалдааг хөнгөвчилнө.	Уул уурхайн бус гадаад худалдаа /экспорт/	Мянган ам.доллар	859.9	1000	2509.5	100.00
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							70.72

"Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх" болон "Гадаад худалдааг хөнгөвчлөх" ТЕЗ-ийн үр дүнг 100 хувь биелүүлсэн нь экспортыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэл 100 хувь биелэхэд нөлөө үзүүлжээ. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 2024 онд 391.9 сая ам.доллар байсан нь нийт экспортын 2.5 хувийг эзэлж байгаа тул тус ТЕЗ-ийн үр дүнгийн гүйцэтгэл 8.97 хувь байсан ч нийт экспорт зорилтот түвшнээс давж биелэхэд үзүүлэх нөлөө бага байсан байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн үр дүнгийн 7 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 2-т үзүүлэв:

Хүснэгт 2.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	1.1.1.Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ.	1. Төмөр замаар тээсэн экспортын ачаа	Сая тонн	27.7	60	45.2	54.18
2		2. Төмөр замын сүлжээний урт	Км	2681	3147	3356.7	100.00
3	1.1.2. Авто замын	1. Улсын чанартай	Хувь	52	54	52.7	35.00

	сүлжээг өргөтгөнө.	авто замын сүлжээнд хатуу хучилттай авто замын эзлэх хувь					
4	1.2.1. Олон улсын жишигт нийцсэн боомтыг нэмэгдүүлнэ.	1. Инженерийн бүрэн хангамжтай боомт	Тоо	12	13	30	100.00
5	1.3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг бий болгоно.	1. Үйлдвэрлэл, технологийн парк	Тоо		2	0	0.00
6	1.3.2. Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулна.	1. Малын гоц халдварт өвчний гаралт	Гоц халдварт өвчний гаралт	592	100	104	99.19
7	1.4.1. Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна.	1. Экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацаа	Цаг	302	72	72	100.00
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							68.54

Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Олон улсын жишигт нийцсэн боомтыг нэмэгдүүлэх, Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг малын халдварт өвчнийг бууруулах, Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулах хөтөлбөрүүдийн үр дүнгийн гүйцэтгэл үр дүнтэй буюу 100 хувь байсан бол Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг бий болгох хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байсан байна.

Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасны дагуу тэргүүлэх чиглэл, ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг өмнөх жилтэй харьцуулж тайлагнаагүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Экспортыг нэмэгдүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 23 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 31.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 14 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 3.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69/	Үр дүнгүй /0-29/		
1.1	Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2	11	1	1	0	9	25.5	19.3


1.2	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	5	0	1	1	3	36.0	29.0
1.3	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2	5	1	1	2	1	62.0	55.0
1.4	Гадаад худалдааг хөнгөвчилнө.	1	2	1	0	0	1	35.0	50.0
Дүн		6	23	3	3	3	14	36.5	31.8

Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх болон боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх ТЕЗ-ийн үр дүнд хамаарах төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “үр дүнгүй” буюу 19.3 хувь болон 29.0 хувьтай байгаа бол хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх болон гадаад худалдааг хөнгөвчлөх ТЕЗ-ийн үр дүнд хамаарах төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 55.0 хувь болон 50.0 хувьтай байна.

Тус чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 23 төсөл, арга хэмжээнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй дараах 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 1.1.1.1.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан 18.9 км холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих;
- 1.3.2.3.Мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- 1.4.1.1."Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн систем бүрэн нэвтрүүлэх.

Ханги-Мандал боомтын терминал барих ажил эхлээгүй, санал хүргүүлэх зэргээр бэлтгэл ажил эхэлж байгаа бол Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих ажлын явцыг тайлагнаагүй байна.



Экспортыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний дундаж биелэлт 31.8% байсан хэдий ч тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл 100% байсан нь төлөвлөсөн төсөл, арга хэмжээ экспортыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө бага, уялдаа муутай төлөвлөгдсөн байгааг харуулж байна. Цаашид ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүнг тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлттэй шууд уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт 2,737.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 98.5 тэрбум төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 3.6 хувьтай байна. Нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн 89.8 хувийг улсын төсөв, 6.9 хувийг гадаадын зээл, тусламж, 3.1 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Хүснэгт 4.Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь

Улсын төсөв	4	82.4	88.5	107.4
Гадаадын зээл, тусламж	6	555.8	6.8	1.2
Төр, хувийн хэвшлийн түншлэл	7	1,885.7	0.0	0.0
Бусад	1	213.3	3.1	1.5
НИЙТ	23	2,737.2	98.5	3.6

Тус тэргүүлэх чиглэлийн хувьд улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл өндөр биелэлттэй, харин улсын төсвөөс бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл хангалтгүй байна.

2. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн үр дүнг гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр тодорхойлж байгаа бөгөөд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Энэ нь төлөвлөгөөнд тусгагдсан суурь түвшин болох 2.7 тэрбум ам.доллар, зорилтот түвшин болох 4 тэрбум ам.доллартой харьцуулж тооцоход хэрэгжилт 15.4 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: ТЕЗ-ийн 5 үр дүнг баталсан бөгөөд үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5. ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	2.1.Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг 7-оор нэмэгдүүлнэ.	Тоо		7	5	71.43
2	2.2.Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Уул уурхайн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин	Хувь	2.2	3	2.4	25.00
3	2.3.Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангасан хувь	Хувь	81	83	88.8	100.00
4	2.4.Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.4	0.8	0	0.00
5	2.5.Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.	Хувь	5	10	10	100.00
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							59.29

“Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх” болон “Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татах” ТЕЗ-ийн үр дүн 100 хувьтай байна. Харин Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд уул уурхайн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин 2.4 болсон нь суурь түвшин болох 2.2, зорилтот түвшин болох 3-тай харьцуулахад хэрэгжилт 25 хувьтай, Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг 0.8-д хүргэхийг зорьсон ч үр дүн гараагүй буюу хэрэгжилт 0 хувьтай байна.

"Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх" болон "Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татах" ТЕЗ-ийн үр дүн 100%-тай байгаа хэдий ч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө багатай байсан байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн үр дүнгийн 11 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	2.1.1. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлнэ.	1. Гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ	Тэрбум ам.доллар	2.5	4	2.9	26.67
2	2.1.2. Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа	Хувь	13	20	0	0.00
3	2.1.3. Гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.	1. Шинэчлэн байгуулсан хэлэлцээр	Тоо	2	6	5	75.00
4	2.2.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ.	1. Нийт нутаг дэвсгэрт хайгуул хийсэн талбайн эзлэх хувь	Хувь	50	60	48	0.00
5	2.2.2. Зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ.	1. Ашиглагдаж байгаа стратегийн орд	Тоо	2	3	2	0.00
6	2.2.3. Боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.	1. Боловсруулах үйлдвэр /хүнд/	Тоо	60	70	54.8	0.00
7	2.3.1. Эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно.	1. Эрчим хүчний компаниудын санхүүгийн алдагдал	Тэрбум төгрөг	-5.7	0	76	100.00
8	2.3.2. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	1. Цахилгаан хангамжийн найдвартай байдлын үзүүлэлт	Исайди / Нэг хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа, цагаар/	18	9	5.6	100.00
9	2.4.1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.4	0.8	0	0.00
10	2.4.2. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. 1,000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал	Тоо	33.6	34.2	36.4	100.00
11	2.5.1. Чөлөөт	1. Арга хэмжээний	Хувь		100	60	60.00

бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	хэрэгжилт					
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж						41.97

Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлэх, банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлэх, зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгох болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлтүүд зорилтот түвшинд хүрээгүй, үр дүнгүй байна.

Монгол Улсын 2024 оны хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтээс дүгнэхэд бизнесийн орчин, уул уурхай, соёлын салбарын хөрөнгө оруулалт хангалтгүй хэрэгжиж байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” чиглэлийн хүрээнд “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 52 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу **33.7** хувь байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 6 төсөл, арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 5 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 20 төсөл, арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 21 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 7. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69/	Үр дүнгүй /0-29/		
2.1	Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	3	9	0	0	4	5	47.8	13.3
2.2	Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	16	1	2	8	5	47.5	33.8
2.3	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	2	18	3	3	4	8	55.0	40.6
2.4	Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	2	7	2	0	2	3	47.9	40.0
2.5	Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	1	2	0	0	2	0	47.5	40.0
НИЙТ		11	52	6	5	20	21	50.2	33.7


Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх ТЕЗ-ийн үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээний дундаж гүйцэтгэл “үр дүнгүй” буюу 13.3 хувьтай байгаа бол бусад ТЕЗ-ийн үр

дүнгийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээний дундаж гүйцэтгэл “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэж байна.

“Үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй дараах 6 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 2.2.3.2."Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг үргэлжлүүлэх;
- 2.3.2.4.Амгалангийн дулааны станцыг өргөтгөх;
- 2.3.2.6.Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх;
- 2.3.2.13.Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих;
- 2.4.2.3.Соёлын баримтат өвийн бүртгэлийн ажлыг эрчимжүүлж, хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулах;
- 2.4.2.4.Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийг хийж гүйцэтгэх.

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний дундаж биелэлт 33.7 хувь байсан бол тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 15.4 хувь байгаа нь төлөвлөсөн арга хэмжээ болон тэргүүлэх чиглэл хоорондын уялдаа бусад тэргүүлэх чиглэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байгааг харуулж байна.



Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээний ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дундаж 59.29 хувь байсан хэдий ч тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл 15.4 хувь байна. ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дундаж 59.29 хувьтай үнэлэгдэхэд "Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх" ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр Засгийн газар хооронд байгуулсан гэрээний тоог авсан бөгөөд 2024 оны гүйцэтгэл 71.4 хувь байгаа нь нөлөөлсөн байна. Энэ нь тус ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт оновчгүй байгааг харуулж байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт 5,847.4 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,008.7 тэрбум төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 17.3 хувь байна. Нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн 57.9 хувийг гадаадын зээл, тусламж, 16.2 хувийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 3.6 хувийг улсын төсөв, 16.5 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Хүснэгт 8.Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	17	298.4	36.6	12.3
Гадаадын зээл, тусламж	8	936.8	584.5	62.4
Төр, хувийн хэвшлийн түншлэл	1	186.0	0.0	0.0
Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	7	3,435.0	223.8	6.5
Бусад	6	990.2	163.8	16.5
НИЙТ	52	5,847.4	1,008.7	17.3

Энэ тэргүүлэх чиглэлийн хувьд гадаадын зээл, тусламжийн санхүүжилт 62.4 хувь, улсын төсвийн санхүүжилт 12.3 хувийн гүйцэтгэлтэй гарч, харин гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд зардлын гүйцэтгэл гараагүй байна.

3.Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр хүний хөгжлийн үзүүлэлтийг 96 дугаар эрэмбээс 92 дугаарт эрэмбэлүүлэх зорилт тавьсан хэдий ч НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Хүний хөгжлийн үзүүлэлтийн 2023-2024 оны тайлан”-гаас үзэхэд Монгол Улсын эрэмбэ 96 дугаар байранд хэвээр байна.

Хүний хөгжлийн индекс /ХХИ/-ийг эрүүл мэнд (дундаж наслалт), боловсрол (сургуульд суралцах жил), амьдралын стандарт (үндэсний орлого) гэсэн 3 гол үзүүлэлтээр хэмждэг боловч Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан ТЕЗ-ийн үр дүнд тэдгээр үр дүнг тусгаагүй, харин тэдгээрийг шууд бусаар хэмжих зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин, 10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо зэрэг шалгуур үзүүлэлтийг тусгасан байна. Монгол Улсын 2021-2022 оны ХХИ-ийн оноо 0.739, 2023-2024 оны ХХИ-ийн оноо 0.741 буюу 0.002 оноогоор өссөн байгаа боловч үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг эрэмбээр тогтоосон учир энэхүү өсөлт тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл болоход нөлөөлөөгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: ТЕЗ-ийн үр дүнг илэрхийлэх 4 үр дүнгийн 8 шалгуур үзүүлэлтийг тогтоосон бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 9-д үзүүлэв:

Хүснэгт 9.ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	3.1.Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	1.Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээ	Хувь	72.9	75.8	70.22	0.00
2		2.Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж	Хувь	36.6	41.6	36.6	0.00
3		3.Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж	Хувь	44.8	49.8	44.8	0.00

4		4.Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн хувь эзлэх	Хувь	58.8	61.2	63.6	100.00
5		5.Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн хувь /их, дээд сургууль/ эзлэх	Хувь	69.8	71.9	72.5	100.00
6	3.2.Нийгмийн баталгааг сайжруулна.	1.Төсвийн санхүүжүүлэх зардлын ДНБ-д эзлэх хувь	Хувь	3.6	3.3	1.7	100.00
7	3.3.Өвчлөл, нас баралтыг бууруулна.	1.Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	Продеци миль /10,000 хүнд, нэгжид ногдох үзүүлэлт/	32.5	26	38.4	0.00
8	3.3.Өвчлөл, нас баралтыг бууруулна.	2.10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо	Продеци миль	973.9	779.1	95.1	100.00
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							50.00

Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, бага болон суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж хувь зэрэг шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй байгаа нь Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулах ТЕЗ-ийн үр дүн хангалтгүй байхад нөлөөлж байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх 15 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 10-т үзүүлэв.

Хүснэгт 10.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	3.1.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн үр чадвартай хүний нөөцийн тоог нэмэгдүүлнэ.	1.Олон улсад магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувь	Хувь	1.3	3.9	1.4	3.85
2	3.1.2.Дээд боловсролын судалгааг эдийн засгийн эргэлтэд оруулна.	1.Гадаадад хэвлүүлсэн импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	Тоо	743	906	1313	100.00
3	3.1.3.Оюуны өмчийг засгийн эргэлтэд оруулна.	1.Шинэ зохиогчийн эрхийн гэрчилгээ	Тоо	996	1000	88	0.00
	3.1.3.Оюуны өмчийг засгийн эргэлтэд оруулна.	2.Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх цахим системд оруулах боть	Тоо	57	60	5750	100.00
	3.1.3.Оюуны өмчийг засгийн эргэлтэд оруулна.	3.Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх цахим системд оруулах материал	Тоо	17159	18000	5750	0.00
	3.1.3.Оюуны өмчийг засгийн эргэлтэд оруулна.	4.Шинэ бүтээл	Тоо	118	125	108	0.00

	3.1.3.Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна.	5.Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь	Хувь	0.13	0.2	0.1	0.00
4	3.1.4.Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.	1.Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь	Хувь	71	76	72	20.00
5	3.1.5.Сургуулийн өмнөх боловсролын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.	1.Сургалтын орчны стандарт хангасан цэцэрлэгийн хувь	Хувь	60	66	63	50.00
6	3.2.1.Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	1.Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа	Хувь	33	33	34	0.03
7	3.2.2.Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	1.Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа	Харьцаа	0.9	0.9	0.84	0.00
8	3.2.3.Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	1.Төрийн албанд зарласан сул орон тоо	Тоо	3243	3243	100	0.00
9	3.3.1.Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	1.Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасан эмийн эзлэх хувь	Хувь	15.9	18.7	27.3	100.00
10	3.3.2.Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1.Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт	Хувь	64.9	67.5	0	0.00
11	3.3.3. Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Хөдөлгөөний хомсдолтой 15-69 насны хүн амын эзлэх хувь	Хувь	21.9	17.5	29	0.00
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							24.93

Тус тэргүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээний үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтээс өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа, нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа, эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасан эмийн эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтүүд зорилтот түвшинд хүрсэн буюу “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

Судалгаа, хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэх, хөдөлгөөний хомсдолтой 15-69 насны хүн амын эзлэх хувийг бууруулах, олон улсад магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувийг өсгөх, сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувийг өсгөх хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 28 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл, арга хэмжээний хэрэгжилт “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 63.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 14 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 8 төсөл, арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 11.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ


Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69/	Үр дүнгүй /0-29/		
3.1	Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	5	12	3	6	3	0	78.3	74.2
3.2	Нийгмийн баталгааг сайжруулна.	3	4	0	4	0	0	92.5	85.0
3.3	Өвчлөл, нас баралтыг бууруулна.	3	12	0	4	5	3	57.5	46.6
НИЙТ		11	28	3	14	8	3	71.4	63.8

Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн ТЕЗ-ийн үр дүнгээс нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 85.0 хувьтай байгаа бол өвчлөл, нас баралтыг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 46.6 хувьтай байна.

Тус чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 28 төсөл, арга хэмжээнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй дараах 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 3.1.4.2.Спорт заал барих;
- 3.1.4.3.Дотуур байр барих;
- 3.1.4.4.Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны лабораторийг тохижуулах.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд төлөвлөсөн "Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилгын зураг, төсөв боловсруулах гэрээ төсөвт өртгөөсөө давсан шалтгаанаар цуцлагдаж дахин зарлагдсанаар хугацаа алдсан бол Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагааны маргааны улмаас хэрэгжилт удааширсан байна. Харин Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх ажлын удааширсан шалтгаан нөхцөлийг тайланд тусгаагүй байна.



Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний дундаж биелэлт 63.8%, ТЕЗ-ийн үр дүнг үнэлэх 8 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар 50 хувь байхад тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн

гүйцэтгэл 0.0% байгаа нь төсөл, арга хэмжээг тэргүүлэх чиглэлийн зорилтыг хангахад чиглэсэн байдлаар харилцан уялдаатай байдлаар оновчтой төлөвлөөгүйг харуулж байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **561.9** тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс **2,545.2** тэрбум төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл **453.0** хувьтай гарч, давж биелжээ. Зарцуулсан нийт зардлын 93.7 хувийг улсын төсвөөс, 6.3 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн эх үүсвэрээс тус тус санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 12. Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	15	387.1	2,385.2	616.1
Гадаадын зээл, тусламж	1	14.8	-	-
Төр, хувийн хэвшлийн түншлэл	1	60.0	160.0	266.7
Бусад эх үүсвэр	1	100.0		
НИЙТ	18	561.9	2,545.2	453.0

Тус тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилтийн гүйцэтгэл 453 хувь буюу төлөвлөсөн санхүүжилтээс давсан гүйцэтгэлтэй байхад тэргүүлэх чиглэлийн үр дүн 0, ТЕЗ-ийн үр дүн 50 хувь, хөтөлбөрийн үр дүн 24.93 хувь, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 63.8 хувьтай байгаа нь санхүүжилтийг үр дүнд чиглэсэн байдлаар оновчтой зарцуулаагүйг харуулж байна.

4.Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг “хүлээн авах гадаад жуулчид”-ийн тоогоор хэмжиж, 2024 онд 1.3 сая гадаадын жуулчдыг хүлээн авахаар төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар 727.4 мянган жуулчин хүлээн авсан буюу 43.0 хувийн хэрэгжилттээ байгаа ба хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд 3 ТЕЗ-ийн үр дүнг баталсан бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 3-д үзүүлэв:

Хүснэгт 13. ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	4.1.Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	1. Шинээр нэмэгдэх аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл	Тоо	0	4	4	100.00

2	4.2.Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ.	1. 4С ангилалд шилжүүлэх нисэх буудал	Тоо	1	5	1	0.00
3	4.3.Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Шинээр баригдах аялал жуулчлалын авто замын урт	Км	0	99.4	72.5	72.94
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							57.65

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар 57.65 хувьтай байна.

“Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” зорилтот үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох “шинээр нэмэгдэх аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл”-ийг 4-өөр нэмэгдүүлснээр зорилтот түвшинд хүрсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн хэдий ч тайланд шинээр нэмэгдүүлсэн аялал жуулчлалын 4 бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхой тусгаагүй байна.

Түүнчлэн “аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл”-ийн статистик үзүүлэлт Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас болон “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”¹-д тусгаагүй байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн үр дүнгийн 3 шалгуур үзүүлэлтийн дундаж хэрэгжилт 40.4 хувьтай байгаа бөгөөд хүрсэн түвшнийг Хүснэгт 14-т үзүүлэв:

Хүснэгт 14.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	4.1.1.Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1.Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь	Хувь	7.2	8	6	0.00
2	4.2.1. Нислэгийн тоог нэмэгдүүлнэ.	1.Нислэгийн тоо	Тоо	18000	30000	23800	48.33
3	4.3.1. Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.	1.Аялал жуулчлалын авто замын сүлжээний урт	Км		99.4	72.5	72.94
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							40.42

“Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилт “үр дүнгүй” буюу 0 хувьтай байна.


Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “үр дүнгүй” буюу 18.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

¹ “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” Үндэсний статистикийн хорооны даргын 2023.12.28-ны өдрийн А/177 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсан байна.

- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 7 төсөл, арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-29 хүртэл хувийн хэрэгжилттэй 23 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 15.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99 хүртэл/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69 хүртэл/	Үр дүнгүй /0-29 хүртэл/		
1	4.1.Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	1	5	-	2	-	3	52.0	32.0
2	4.2.Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ.	1	5	-	-	1	4	42.0	10.0
3	4.3.Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	25	-	3	6	16	44.2	18.0
НИЙТ		3	35	-	5	7	23	45.0	18.9



Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, нисэх буудлыг өргөтгөх замаар агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын авто замын уртыг нэмэгдүүлэх гэсэн агуулга бүхий 3 ТЕЗ-ийн үр дүнг баталсан боловч зочид буудлын хүрэлцээ, дотоодын зам тээврийн тохь тух, хэрэглээний үнийн индекс зэрэг бусад жуулчдын ач холбогдол өгөх хүчин зүйлсийг ТЕЗ-ийн үр дүнгээр тодорхойлоогүй байна.

"Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх" ТЕЗ-ийн үр дүнгийн хүрсэн түвшин нь 100.0 буюу төлөвлөснөөс 25 дахин өндөр байгаа боловч тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэл 43.0 хувь байгаа нь тус шалгуур үзүүлэлтийг ТЕЗ-ийн үр дүнг хангахад чиглэсэн байдлаар оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **801.4** тэрбум төгрөг төлөвлөснөөс **172.0** тэрбум төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл **21.5** хувь байна.

Хүснэгт 16.Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	23	652.5	172.0	26.4
Гадаадын зээл, тусламж	1	75.2	-	0.0
Төр, хувийн хэвшлийн түншлэл	5	72.8	-	0.0
Бусад эх үүсвэр	1	1.0	-	0.0
НИЙТ	35	801.4	172.0	21.5

Аялал жуулчлалыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн хэдий ч зөвхөн улсын төсвөөс зардал гарч, бусад эх үүсвэрээр төсөв зарцуулагдаагүй байна.

5.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Хүнсний аюулгүй байдлын индекс гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн ч уг үзүүлэлтийг тооцох аргачлал, тоон үзүүлэлт нь батлагдаагүй учир шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тооцох боломжгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ гэсэн үр дүнг баталсан бөгөөд хүрсэн түвшнийг Хүснэгт 17-д үзүүлэв.

Хүснэгт 17.ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэт -гэл
1	5.1.Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	1.Гол нэр төрлийн 16 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамж	Хувь	92.8	95	-	-
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							-

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшнийг нэмэгдүүлэх гэсэн үр дүнг баталсан бөгөөд хүрсэн түвшнийг Хүснэгт 18-д үзүүлэв.

Хүснэгт 18.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл
1	5.1.1.Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшинг	1.Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр нэмэгдүүлэх хувь	Хувь		80		-

нэмэгдүүлнэ.						
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж						-

Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшнийг нэмэгдүүлэх гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшнийг 80 хувьд хүргэхээр зорьсон боловч хэрэгжилтийг тайлагнаагүй, тус үзүүлэлтийг тооцох аргачлал батлагдаагүй, тооцох боломжгүй байна.

Үндэсний статистикийн хорооноос "Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд" гэсэн тусгайлсан тайланг 2014 оноос гаргаж ирсэн байх тул холбогдох индексийг яаралтай батлах шаардлагатай байна.

Тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгээр хүнсний хангамжийн асуудлыг тусгасан байх боловч хүнсний аюулгүй байдлын бусад гол үзүүлэлт болох хүнсний чанар, баталгаажуулалт, хүрэлцээ зэргийн талаар тусгаагүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 5 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 64.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээ байхгүй;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 1 төсөл, арга хэмжээ;
- “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 1 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 19.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69/	Үр дүнгүй /0-29/		
5.1	Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	1	5	0	3	1	1	78.0	64.0
НИЙТ		1	5	0	3	1	1	78.0	64.0

ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнгээс “Хүнсний үйлдвэрлэлийн дэмжлэгийг эцсийн үр дүнд чиглүүлж оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизм хэрэгжүүлэх”, “Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх” гэсэн 3 төсөл, арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй байна.



“Үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 1 төсөл, арга хэмжээ байна. 5.1.1.2.Хүнсний гол нэрийн

бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад Үйлдвэрлэл, технологийн парк /ҮТП/ байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих гэсэн арга хэмжээний гол үр дүн гараагүй, шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй байна.

Хүнсний аюулгүй байдал нь улс орны аюулгүй байдлын нэн чухал үзүүлэлт боловч тус тэргүүлэх чиглэлийг хэмжих шалгуур үзүүлэлтийг батлаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, зохицуулах чиглэлээр зохион байгуулалттай холбоотой төсөл, арга хэмжээ оновчтой төлөвлөлт хийж хэрэгжүүлсэн хэдий ч хянах болон томоохон бүтээн байгуулалт бүхий санхүүжилттэй холбоотой төсөл, арга хэмжээг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд амжихгүй тул санхүүжилтийг бүрэн шийдвэрлэх шаардлагатай байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **174.9** тэрбум төгрөг төлөвлөснөөс **116.4** тэрбум төгрөгийн зардал гарч, санхүүжилт **66.6** хувь байна. Нийт зарцуулсан зардлын 97.6 хувийг улсын төсөв, 2.4 хувийг гадаадын зээл, тусламж эзэлж байна.

Хүснэгт 20. Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	4	174.4	113.7	65.2
Гадаадын зээл, тусламж	1	0.5	2.8	551.0
Нийт	5	174.9	116.4	66.6

6. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлийн үр дүнг Хотын хөгжлийн үзүүлэлт гэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн бөгөөд 2024 оны үзүүлэлт нь 2025 оны 6 сард гарах тул 2023 оны үзүүлэлтээр тайлагнасан байна. Энэхүү үзүүлэлтийн 2023 оны хүрсэн түвшин 0.5022 байгаа ба хүрсэн түвшний гүйцэтгэл 0.0 хувь байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2 ТЕЗ-ийн үр дүнг баталсан бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 21-д үзүүлэв:

Хүснэгт 21. ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	6.1. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	1. Нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд /оргил ачааллын үед/	Км/ц	10	22	13	25.00
2	6.2. Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж	Мкг/м3	41	31	45	0.00
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							12.50

Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь Нийслэлийн замын хөдөлгөөний оргил ачааллын үе дэх

дундаж хурдыг км/цагаар тооцох бөгөөд 2024 оны зорилтот түвшин 22 гэж төлөвлөснөөс хүрсэн түвшин 13 болсноор гүйцэтгэл 25.0 хувьтай байна.

Агаарын бохирдлыг бууруулахад дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ТЕЗ-ийн үр дүнг Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд зорилтот түвшин 31 мкг/м3 байхаас 45 мкг/м3 болж давсан тул гүйцэтгэл 0.0 хувь байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн 7 үр дүнгийн 10 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 22-т үзүүлэв:

Хүснэгт 22.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	6.1.1. Авто замын ачааллыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлнэ.	1. Түгжрэлийг бууруулсан хэмжээ	Хувь		8	0	0.00
2	6.1.2. Авто машингүй зорчих замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. 1,000 хүнд ногдох явган хүний зам	Км2	112	128	139.1	100.00
	6.1.2. Авто машингүй зорчих замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2. 1,000 хүнд ногдох дугуйн зам	Км	0.1	0.1	7.33	100.00
3	6.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Нийслэлийн нийтийн тээврээр зорчдог хүн амын эзлэх хувь	Хувь	34	56	41.9	35.91
4	6.1.4. Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно.	1. Нийслэлийн авто замын үндсэн сүлжээний урт	Км	1135	1207	1231.3	100.00
	6.1.4. Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно.	2. Авто замын уулзварын нэвтрүүлэх чадвар	Хувь	24	15	31	0.00
	6.1.4. Түгжрэлийг бууруулах дэд бүтцийг бий болгоно.	3. Нийслэл дэх төмөр замын гарам	Тоо	172	168	171	25.00
5	6.2.1. Инженерийн дэд бүтцийн хүртээмж, найдвартай байдлыг дээшлүүлнэ.	1. Инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь	15	100	69.55	64.18
6	6.2.2. Гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулна.	1. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь	23	28	27	80.00
7	6.2.3. Шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж	Хувь		50	45	90.00
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							56.74

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд 23 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл, арга хэмжээний хэрэгжилт “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 60.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 4 төсөл, арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 9 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ;


- “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ тус тус байна.

Хүснэгт 23.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
				Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-99/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-69/	Үр дүнгүй /0-29/		
6.1	Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	4	15	3	3	6	3	50.5	50.5
6.2	Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3	8	1	6	1	0	77.5	77.5
НИЙТ		7	23	4	9	7	3	59.9	59.9

Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 23 төсөл, арга хэмжээнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 6.1.1.1.Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, нийтийн тээврийн салбарыг бие даасан болгох
- 6.1.2.1.Явган хүний зам барих
- 6.1.3.5.Цахилгаан болон хийн автобусаар парк шинэчлэлт хийх
- 6.2.3.2.“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэх /инженерийн байгууламж/



Нийслэлд тусгай замын автобусны сүлжээ байгуулах /BRT/ ажлыг эхлүүлэх, Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох, “Богдхан төмөр зам” төслийг эхлүүлэх зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг 1 жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь хугацаа богинотой, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд цаг хугацаа, санхүүжилт шаардагдаж байна.

Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг "Нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд /оргил ачааллын үед/", "Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж" гэж баталсан бөгөөд хэрэгжилт нь 25% болон 0% буюу тэргүүлэх чиглэлийн биелэлттэй ойролцоо түвшинд байгаа нь ТЕЗ-ийн үр дүнг оновчтой тогтоосныг харуулж байна.

Харин хөтөлбөрийн дундаж үнэлгээ 56.74%, төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ 59.9% байгаа нь тэдгээр төсөл, арга хэмжээ нь ерөнхийдөө тэргүүлэх чиглэлтэй уялдаа сул байгааг харуулж байна.

Агаарын бохирдлыг бууруулах ТЕЗ-ийн үр дүнг төлөвлөхдөө зөвхөн гэр хорооллыг инженерийн дэд бүтэц, шинэ суурьшлын бүсэд орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь хангалтгүй байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **3,761.2** тэрбум төгрөг төлөвлөснөөс **1,048.2** тэрбум төгрөгийн зардал гарснаар **27.9** хувийн төсвийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн 7.5 хувийг улсын төсөв, 31.8 хувийг гадаадын зээл, тусламж, 60.7 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зардал эзэлж байна.

Хүснэгт 24. Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	6	711.9	79.2	11.1
Гадаадын зээл, тусламж	3	117.8	333.1	282.8
Төр, хувийн хэвшлийн түншлэл	2	2,316.3	-	
Бусад	9	615.2	636.0	103.4
НИЙТ	23	3,761.2	1,048.2	27.9

Энэхүү тэргүүлэх чиглэлийн хувьд гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл өндөр биелэлттэй, харин төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулалт гараагүй байна.

7. Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн үр дүнг Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж үзүүлэлтээр тодорхойлохоор төлөвлөсөн. Гэвч Дэлхийн банкнаас тус үзүүлэлтийг 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тооцож гаргадаг бөгөөд 2024 оны үзүүлэлт гарах хугацаа болоогүй гэх тайлбарыг ирүүлсэн тул шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин тодорхойгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд 5 ТЕЗ-ийн үр дүнг баталсан бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 25-д үзүүлэв:

Хүснэгт 25. ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл
1	Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын индекс	Эрэмбэ	139	129	-	-
2	Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө	Эрэмбэ	137	124	-	-
3	Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх иргэд, аж ахуйн нэгж,	Тоо	904	600	1311	0.00

		байгууллагаас ирүүлсэн гомдол					
4	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	Батлан хамгаалах чадавх	Хувь	70	72	72	100.00
5	Шүүх шинжилгээни й дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	Шүүхийн сахилгын хороонд гаргасан гомдлын тоо	Тоо	639	590	321	100.00
ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							66.67

Тус ТЕЗ-ийн үр дүнгийн хувьд ЗГ-аас Монгол Улсын эрэмбийг тайлагнаж ирүүлсэн нь тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн тайлантай зөрчилтэй тайлан ирүүлсэн. Иймд тэргүүлэх чиглэлийг баримталж үнэлэх боломжгүй гэж үзсэн.

Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх ТЕЗ-ийн үр дүнгийн хүрсэн түвшнийг зорилтот түвшинтэй адилаар тайлагнасан боловч эх сурвалж тодорхойгүй байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн үр дүнгийн 12 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 26-д үзүүлэв:

Хүснэгт 26.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
1	Авлигын гэмт хэргийг бууруулна.	Авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эзлэх хувь	Хувь	71.9	67	59.9	0.00
2	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/	Хувь	1.9	2.3	7.76	100.00
3	Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	Төрийн үйлчилгээг цахимаар хүртэгчид	Мянган хүн	1,488	2,000	1,947	89.60
4	Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс /НҮБ-ын цахим засгийн судалгаа/	Оноо	0.7	0.1	0.9	100.00
5	Газрын харилцааны үйлчилгээг хялбаршуулна.	1,000 газар эзэмшигчид ногдох маргаан, зөрчил	Тоо	5.1	4.1	0	0.00
6	Эрэн хайх, аврах ажиллагааны чанарыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	60	100	100	100.00
7	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдал хангагдана.	Нийт үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд, гэр бүлээс үйлчилгээ авсан хүүхэд, гэр бүлийн эзлэх хувь	Хувь	55	85	85	100.00
8	Цэргийн мэргэжил олгох сургалт болон Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.	Цэргийн мэргэжил олгох сургалтад оролцогчид	Хүн	500	2,000	1000	33.30
		Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчид	Хүн	120	1,000	900	88.60
9	Хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.	Хил орчмын дэглэмийн зөрчил	Хүн/удаа	85/819	68/655	72/308	76.50

10	Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг нэмэгдүүлнэ.	Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол	Тоо	21	17	21	0.00
		Давтан шинжилгээ	Тоо	549	440	628	0.00
		Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж					

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 4 шалгуур үзүүлэлт;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 3 шалгуур үзүүлэлт;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 1 шалгуур үзүүлэлт;
- “үр дүнгүй” буюу 0-29 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 шалгуур үзүүлэлт байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдал хангагдах, Эрэн хайх, аврах ажиллагааны чанарыг нэмэгдүүлэх, Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт хангагдсан бол Авлигын гэмт хэргийг бууруулах, Газрын харилцааны үйлчилгээг хялбаршуулах, Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт зорилтот түвшнийг хангаагүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: Засаглалын үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 20 төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт 72.5 хувь байна. Үүнд:

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 3 төсөл, арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 12 төсөл, арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн хэрэгжилттэй 5 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 27.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ


ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Хэрэгжилт				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
		Үр дүнтэй 100	Тодорхой үр дүнд хүрсэн 70-99	Эрчимжүүлэх шаардлагатай 30-69	Үр дүнгүй 0-29		
7.1.Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	2	0	2	0	0	100.0	80.0
7.2.Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	10	0	6	4	0	73.0	62.0
7.3.Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	2	0	2	0	0	80.0	80.0
7.4.Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	3	1	1	1	0	80.0	73.3
7.5.Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	3	2	1	0	0	96.7	96.7
Нийт	20	3	12	5	0	81.0	72.5

“Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн 20 төсөл, арга хэмжээнээс дараах 3 төсөл, арга хэмжээ “үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн байна. Үүнд:

- 7.5.1.2.Бүсийн шүүх шинжилгээний төв байгуулах /Дорнод, Ховд, Дархан/;

- 7.5.1.3.Шинэ төрлийн шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж авах;
- 7.4.2.1.Хилийн боомтын аюулгүй байдлыг хангаж, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системд холбох.

Харин “НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд инженерийн болон тусгай хүчний ротыг оролцуулах бэлтгэлийг хангах” арга хэмжээг 50 хувийн хэрэгжилттэй “тайлан нууц” гэх байдлаар тайлагнасан тул хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөл тодорхойгүй байгаа бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 7.2.3.1-д тусгагдсан “Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах” төсөл, арга хэмжээ удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан бүрэн хэрэгжээгүй байна.



Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3-т Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлд хийсэн дүн шинжилгээний үр дүн, цаашид авах арга хэмжээний тодорхой саналыг тусгаж ирүүлэхээр заасан хэдий ч

Засгийн газраас дээрх шаардлагыг хангаж ирүүлээгүй болно. Засаглалын үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс “үр дүнгүй” ангилалд багтсан төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Засаглалын үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн нийт арга хэмжээний дундаж 72.5%-тай байсан боловч Дэлхийн банкнаас гаргадаг засаглалын индекс 2024 оны хувьд гараагүй байна гэж тайлагнасан бөгөөд 2023 оны байдлаар авч үзэхэд засаглалын индекс тооцоход ашиглагддаг 6 үзүүлэлт буурсан байдалтай байна.

Түүнчлэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд холбогдох ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдээр холбогдох үзүүлэлтийн эрэмбийг баталсан. Гэвч Дэлхийн банкнаас тэдгээр үзүүлэлтээр улс орнуудыг эрэмбэлэхдээ шалгуур үзүүлэлтэд зааснаар шууд эрэмбэлэхээ больж, хамгийн өндөр оноотой улсын эрэмбийг 100 гээд, түүнтэй харьцуулсан эрэмбийг гаргадаг болсон байгаа тул шалгуур үзүүлэлтийг шинэчлэх шаардлагатай байна. Ингэхдээ улс орны эрэмбээр шалгуур үзүүлэлт тогтоох нь бусад орны оноо өөрчлөгдсөнөөс хамааран манай улсын бодит өөрчлөлт шалгуур үзүүлэлтээр харагдахгүй байх магадлалтай тул, улс орны эрэмбээр бус үзүүлэлтийг хэмжих оноогоор тогтоох шаардлагатай байна.

Тус тэргүүлэх чиглэлийг Дэлхийн банкнаас засаглалын индексийг тооцоход ашигладаг 6 үзүүлэлтээс Авлигын хяналт, Засгийн газрын үр нөлөө гэсэн 2 үзүүлэлт ТЕЗ-ийн үр дүнгээр батлагдсан байгаа боловч бусад 4 үзүүлэлт (Иргэдийн дуу хоолой ба хариуцлага, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл/терроризмгүй байдал, Засаглалын чанар, Хуулийн засаглал) тусгагдаагүй байх тул холбогдох үзүүлэлтийг тусгах шаардлагатай байна.

2024 онд Авлигын индексийг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-д 109-д хүргэхээр, харин уг тогтоолын 2 дугаар хавсралтаар 129-д хүргэхээр зөрүүтэй батлагдсан байна.

Мөн ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг уялдаа холбоо бүхий оновчтой төлөвлөөгүйн улмаас үр дүнг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний дагуу тайлагнах, улмаар үнэлэх боломжгүй байдлыг үүсгэж байна.

Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **100.5** тэрбум төгрөг төлөвлөснөөс **73.1** тэрбум төгрөгийн зардал гарснаар **72.7** хувийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 28. Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	14	88.3	37.1	42.0
Гадаадын зээл, тусламж	4	12.2	35.9	295.8
НИЙТ	20	100.5	73.1	72.7

Нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн 50.8 хувийг улсын төсөв, 49.2 хувийг гадаадын зээл, тусламж эзэлж байна. Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн гүйцэтгэл 42.0 хувьтай гарсан байна.

8. Ногоон хөгжлийг дэмжинэ.

Тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: “Ногоон хөгжлийг дэмжинэ.” тэргүүлэх чиглэлийн болон ТЕЗ-ийн үр дүнг адил үзүүлэлтээр буюу Иелийн их сургуулийн судалгаагаар тогтоодог “Байгаль орчны гүйцэтгэлийн индекс” үзүүлэлтээр хэмжих, уг үзүүлэлтийг 2024 онд 130-д хүргэхээр төлөвлөжээ. 2024 оны Иелийн их сургуулийн судалгаагаар тус үзүүлэлт 143 дугаар байранд эрэмбэлэгдэж зорилтот түвшинд хүрээгүй буюу гүйцэтгэл 48.0 хувь байна.

Хүснэгт 29. Тэргүүлэх чиглэл болон ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
Тэргүүлэх чиглэлийн үр дүн							
1	8. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	1. Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	155	130	143	0.48
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн							
1	8.1. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	1. Байгаль орчны гүйцэтгэлийн индекс	Эрэмбэ	155	130	143	0.48

Ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн нийт арга хэмжээний дундаж биелэлт 83.8 хувь байсан хэдий ч тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 48.0 хувьтай байна. Тус индексээр Монгол Улс 2022 онд 29.6 оноотойгоор дэлхийн 180 улсаас 155-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 оны гүйцэтгэлээр 37.2 оноотойгоор 143-т эрэмбэлэгдэж, ахиц гарч 13 байр урагшилсан байна. Гэсэн хэдий ч зорилтот түвшнийг хэт өндөр буюу 2 жилийн дотор 25 байр урагшлахаар тогтоосонтой холбоотойгоор тэргүүлэх чиглэлийн биелэлт 50 хувьд хүрэхгүй гарсан байна.

Хөтөлбөрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт: Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан хөтөлбөрийн 4 үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг Хүснэгт 30-д үзүүлэв:

Хүснэгт 30.Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
1	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	7.7	8.5	8.48	97.5
2	Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ	Хувь	10	12.5	12.6	100.0
3	Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлнэ.	Төслийн хэрэгжилт	Хувь	0	10	7	70.0
4	Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.	Тарималжуулсан ургамлын зүйл	Тоо	10	12	19	100.0
		Амьдрах орчныг тэтгэх арга хэмжээ авсан болон зориудаар өсгөн үржүүлсэн нэн ховор, ховор амьтны зүйл	тоо	3	5	6	100.0
Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний дундаж							93.5

Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ, тарималжуулсан ургамлын зүйл, амьдрах орчныг тэтгэх арга хэмжээ авсан болон зориудаар өсгөн үржүүлсэн нэн ховор, ховор амьтны зүйл шалгуур үзүүлэлтүүд зорилтот түвшинд бүрэн хүрсэн бол Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлтүүд “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн хэрэгжилттэй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт: “Ногоон хөгжлийг дэмжих” тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 8 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд дундаж хэрэгжилт “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 83.8 хувьтай байна:

- “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ;
- “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ;
- “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

Хүснэгт 31.Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт				ЗГ-ын үнэлгээ, хувь	ТГ-ын үнэлгээ, хувь
		Үр дүнтэй 100	Тодорхой үр дүнд хүрсэн 70-99	Эрчимжүүлэх шаардлагатай 30-69	Үр дүнгүй 0-29		
8.1.Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	8	5	2	1	0	86.3	83.8

“Ногоон хөгжлийг дэмжинэ.” тэргүүлэх чиглэлийн хүрээнд “үр дүнтэй” хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 8.1.1.2.Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах;
- 8.1.2.1.Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх;
- 8.1.2.2.Улаанбаатар хотын хог хаягдлыг дахин боловсруулах төсөл хэрэгжүүлэх;
- 8.1.4.1.Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох;
- 8.1.4.2.Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Онги-Цагаан бургастай төслийг эхлүүлэх төсөл, арга хэмжээний хувьд холбогдох ажлын хэсгүүд байгуулагдан бэлтгэл хангах ажлууд хийгдэж байгаа буюу хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт болон ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг яг ижил тогтоосон байгаатай холбоотойгоор хэрэгжилт 48% буюу ижил үр дүнтэй байна. Үүнийг тус тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан 93.5% хэрэгжилттэй 5 хөтөлбөр, 83.8%-ийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээтэй харьцуулахад 35-45 хувийн зөрүүтэй байгаа нь тэргүүлэх чиглэл болон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг уялдаа муутай, үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөөгүйг харуулж байна.


Санхүүжилтийн гүйцэтгэл:

Энэхүү тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд нийт **10.2** тэрбум төгрөг төлөвлөснөөс **30.1** тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, санхүүжилтийн төлөвлөгөө давж биелжээ. Нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн 88.4 хувийг улсын төсөв, 11.6 хувийг гадаадын зээл, тусламж

Улсын
үүсвэртэй

гүйцэтгэл
харин
тусламжаар
арга

гүйцэтгэл



зээлж байна.
төсвийн эх
арга
хэмжээнүүдийн
санхүүжилтийн
өндөр биелэлттэй,
гадаадын зээл,
санхүүжүүлсэн
хэмжээнүүдийн
санхүүжилтийн
хангалтгүй байна.

Хүснэгт 32.Санхүүжилтийн гүйцэтгэл

Эх үүсвэр	Нийт арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /тэрбум төгрөг/		
		Төл.	Гүйц.	Биелэлт, хувь
Улсын төсөв	5	3.3	26.6	815.4
Гадаадын зээл, тусламж	2	6.9	3.5	50.6
НИЙТ	8	10.2	30.1	296.4

Тус тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт давсан гүйцэтгэлтэй байхад тэргүүлэх чиглэлийн болон ТЕЗ-ийн үр дүн 48%-тай байгаа нь санхүүжилтийг үр дүнд чиглэсэн байдлаар оновчтой төлөвлөөгүйг харуулж байна.

**ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЬ
“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”,
“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР”-Т ЗААСАН ЗОРИЛТОТ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН
ЭСЭХ**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг дараах шалтгааны улмаас төсөл, арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан тооцох боломжгүй байна. Үүнд:

1.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бодлогын зорилго, зорилт, арга, хэмжээний хүрэх үр дүн, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг жил тус бүрээр тодорхойлоогүй;

2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд агуулгын хувьд ойролцоо төсөл, арга хэмжээ тусгагдсан байх боловч яг ижил арга хэмжээ тусгагдаагүй байгаа тул хэрэгжилтийг харьцуулах боломжгүй;

3.Мөн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 243 зорилт, арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлт түүний суурь түвшин, зорилтот түвшнийг батлаагүй байх тул түүний хэдэн хувьд хүрснийг тооцох боломжгүй;

4.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй, арга хэмжээ тус бүрийн суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг батлаагүй байгаа тул түүний хэдэн хувьд хүрснийг арга хэмжээ бүрээр харьцуулан шинжлэх боломжгүй.

Иймд Тамгын газраас Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээтэй хэрхэн уялдаж байгааг шинжиллээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-г батлахдаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан бодлогын үндэслэлийг зааж баталсан тул, бодлогын баримт бичгүүдийг бүрэн уялдсан гэж авч үзэв.

Хүснэгт 33.Бодлогын баримт бичгийн нийцэл

Д/д	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл	Төсөл, арга хэмжээ	Бодлогын баримт бичгүүдийн уялдаа
-----	---	--------------------	-----------------------------------

1	Экспортыг нэмэгдүүлнэ.	23	100
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	52	
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	28	
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	35	
5	Хүнсний хангамж аюулгүй байдлыг сайжруулна:	5	
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	23	
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	20	
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	8	
Нийт		194	-

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ТЭДГЭЭРИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд хөтөлбөрийн 65 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 26 шалгуур үзүүлэлт бүрэн хэрэгжээгүй буюу үр дүнгүй байна.

Д/д	Тэргүүлэх чиглэл	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт үр дүнгүй шалгуур үзүүлэлт	
			Тоо	Хувь
1	Экспортыг нэмэгдүүлнэ.	7	1	14.3
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	11	6	54.5
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	15	11	73.3
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	3	1	33.3
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	1	0	0.0
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	10	3	30.0
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	13	4	30.8
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	5	0	0.0
Дүн		65	26	40.0

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлд тусгагдсан хөтөлбөрөөс бүрэн хэрэгжээгүй шалгуур үзүүлэлт нь бусад тэргүүлэх чиглэлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 54-73% байсан нь тус 2 тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 15.4% болон 0% хувь байхад нөлөөлжээ. Харин экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн хувьд үр дүнгүй хөтөлбөрийн хувь харьцангуй бага буюу 14.3% байсан бол тус тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 100% байна.


Засгийн газраас ирүүлсэн “Монгол Улсын 2024 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайланд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтад заасны дагуу бүрэн хэрэгжээгүй хөтөлбөрийн шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний саналыг тайлагнаж ирүүлээгүй байна.

Иймд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 194 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас “үр дүнгүй” буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 65 төсөл, арга хэмжээг ангилан үзлээ.

Хүснэгт 34.0-29 хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээний шалтгаан

Тэргүүлэх чиглэл	Төсөл, арга хэмжээний тоо	Хэрэгжилт үр дүнгүй төсөл, арга хэмжээ	
		Тоо	Хувь
1.Экспортыг нэмэгдүүлнэ.	23	14	60.9

2.Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	52	21	40.4
3.Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	28	3	10.7
4.Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	35	23	65.7
5.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	5	1	20.0
6.Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	23	3	13.0
7.Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	20	0	0.0
8.Ногоон хөгжлийг дэмжинэ.	8	0	0.0
Дүн	194	65	33.5



Бүрэн хэрэгжээгүй буюу 0-29 хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээг нийтлэг шалтгаанаар нь ангилан үзвэл 53.8% нь зохион байгуулалт удаашралтай, 9.23% нь төсөв, санхүүжилт шийдэгдээгүй, 7.69% нь шийдвэр гаргалт удааширсантай, 6.51% нь хэрэгжилтийг дутуу тайлагнасантай холбоотой байна. Харин 10.77%-ийн хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тайлбарлаагүй байна.

---oOo---

ДӨРӨВ.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүжилтийн гүйцэтгэлээр нь авч үзэхэд Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын гүйцэтгэл 453.0 хувь, Ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийнх 296.4 хувьд хүрч тус тус давж биелсэн бол бусад тэргүүлэх чиглэлийн санхүүжилтийн зардлын гүйцэтгэл 3.6 хувь-72.7 хувь байгаа нь хангалтгүй байна.

Гүйцэтгэлийн тайланг хэрэгжүүлэхэд зарцуулсан нийт санхүүжилтийн 50.0 хувийг хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулахад, 20.6 хувийг Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулахад, 19.8 хувийг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд голлон зарцуулсан байна.

Хүснэгт 35.Улсын хөгжлийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд тусгагдсан бодлого, зорилго, арга хэмжээ, санхүүжилтийн гүйцэтгэл

Д/д	Тэргүүлэх чиглэл	Зорилт (үр дүн), арга хэмжээний тоо			Нийт санхүүжилтийн хэмжээ /тэрбум.төг/		
		ТЕЗ	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Экспортыг нэмэгдүүлнэ.	4	6	23	2,737.2	98.5	3.6
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	5	11	52	5,847.4	1,008.7	17.3
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	3	11	28	561.9	2,545.2	453.0
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	3	3	35	801.4	172.0	21.5
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	1	1	5	174.9	116.4	66.6
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	2	7	23	3,761.2	1,048.2	27.9
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	5	10	20	100.5	73.1	72.7
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	1	4	8	10.1	30.1	296.4
Дүн		24	53	194	13,994.6	5,092.1	36.4

Гүйцэтгэлийн тайланд тусгаснаар зарцуулсан зардлыг эх үүсвэрээр нь ангилж үзэхэд, нийт зарцуулалтын **55.5** хувь (2,828.0 тэрбум.төг)-ийг улсын төсөв, **21.2** хувь (1,077.5 тэрбум.төг)-ийг гадаадын зээл, тусламж, **18.9** хувь (962.9 тэрбум.төг)-ийг орон нутгийн төсөв, бусад холимог эх үүсвэр, **4.4** хувь (223.8 тэрбум.төг)-ийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4,520.8 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн боловч нэг ч арга хэмжээнд зардлын гүйцэтгэл гараагүй байна. Энэ нь бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц, санхүүжилтийн талаар тайлан ирүүлээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 36.Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд тусгагдсан санхүүжилт, түүний эх үүсвэр /тэрбум төгрөг/

Д/д	Тэргүүлэх чиглэл	Нийт гүйцэтгэл		УТ* ²	ГЗТ*	ТХХТ*	ГДХО*	Бусад*
		Гүйц.	Биелэлт хувь	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.
1	Экспортыг нэмэгдүүлнэ.	98.5	3.6	88.5	6.8	0.0	0.0	3.1
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1,008.7	17.3	36.6	584.5	0.0	223.8	163.8
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	2,545.2	453.0	2,385.2	0.05	0.0	0.0	160.0
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	172.0	21.5	172.0	0.0	0.0	0.0	0.0
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	116.4	66.6	2.8	113.6	0.0	0.0	0.0
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	1,048.2	27.9	79.2	333.1	0.0	0.0	636.0
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	73.1	72.7	37.1	35.9	0.0	0.0	0.0
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	30.1	296.4	26.6	3.5	0.0	0.0	0.0
ДҮН		5,092.1	36.4	2,828.0	1,077.5	0.0	223.8	962.9

ТАВ.ДҮГНЭЛТ

Хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхтэй холбоотой:

1.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дундаж биелэлт 34.4 хувь байгаа бөгөөд хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлийн биелэлт 0, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн биелэлт 15.4 хувь байна. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт батлагдаагүй байна.

2.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 24 ТЕЗ-ийн үр дүнгийн биелэлтийн дундаж 52.99 хувь, нийт 53 хөтөлбөрийн биелэлтийн дундаж 52.34 хувь, нийт 194 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 45.1 хувь байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт, хэрэгжилтийн хувь харилцан хамааралгүй, зүй тогтолгүй байгаа нь үр дүнг хэмжихээр урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтийн уялдаа холбоо сул, үр дүнд чиглээгүй, хоорондоо зөрчилтэй байна.

3.Төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тайлбарлахгүй орхигдуулах, цаашид авах арга хэмжээний саналыг ирүүлэхгүй байх зэргээр төлөвлөгөөний хэрэгжилтийг хуульд заасан шаардлагын дагуу иж бүрэн тайлагнахгүй байна.

* Тайлбар: Улсын төсөв, Гадаад, зээл тусламж, ТХХТ-төр, хувийн хэвшлийн түншлэл, ГДХО-гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бусад – орон нутгийн төсөв, бусад хамтарсан эх үүсвэр

Төлөвлөлт, тайлагналттай холбоотой:

1.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг хэмжигдэхүйц байдлаар бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг урьдчилан тооцоолоогүй зэрэг төлөвлөлтийн алдаа байна.

2.Зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа хүрсэн түвшний үр дүнг тайлагнахгүй орхигдуулах, зорилтын агуулгаас зөрүүтэй ажлыг тайлагнах, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнахгүй байх, зарцуулсан санхүүжилтийн гүйцэтгэлийг орхигдуулах, түүнчлэн санхүүжих дүн, эх үүсвэр тусгагдаагүй төсөл, арга хэмжээнд төсөв зарцуулж, тайлагнасан зэрэг тайлагналттай холбоотой нийтлэг алдаа байна.

3.Улс орны хэмжээнд богино, дунд, урт хугацааны баримт бичгүүдийг боловсруулахдаа хэрэгжүүлэгч байгууллагуудаас санал авч нэгтгэх замаар боловсруулдгаас шалтгаалан бодлогын баримт бичгүүд хоорондын уялдаа сул, тэдгээрт харилцан хамааралгүй төсөл, арга хэмжээ тусгагдан батлагддаг тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу бусад баримт бичигт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг шинжлэн дүгнэх боломжгүй байна. Цаашид урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнд нийцүүлэн богино, дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулдаг байх нь зүйтэй.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

1.Цаашид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтад заасны дагуу тэргүүлэх чиглэл, ТЕЗ, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг өмнөх жилтэй харьцуулж, гүйцэтгэлийн тайланд тусгах асуудлыг хуульд заасан шаардлагын дагуу иж бүрэн тайлагнах;

2.Тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн уялдаа холбоог сайжруулж, үр дүнг хэмжигдэхүйц байдлаар оновчтой төлөвлөх нь хэрэгжилтийн үр дүнг бодитой харьцуулах ач холбогдолтой;

3.Цаашид төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтыг сайжруулж, санхүүжилт, төсвийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавих;

4.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд зөвхөн тухайн жилдээ хийж гүйцэтгэх боломжтой ажлыг эрэмбэлж төлөвлөн тусгах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээг бодит тооцоололд үндэслэн үнэн зөв төлөвлөх замаар хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;

5.Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд оролцогч бүх талаас төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, санхүүжилтийн зарцуулалтын талаарх тайлан, мэдээллийг тогтсон хугацаанд авдаг байх, үр дүнд үнэлгээ, дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээг иж бүрэн хийдэг, тайлагналтыг нийтэлдэг “цахим мэдээллийн нэгдсэн сүлжээ”-г боловсронгуй болгох, сайжруулах шаардлагатай байна.

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГҮЙ
(0-29) ҮНЭЛЭГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Үр дүнгүй буюу “0-29” хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээ

Д/Д	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ	УИХТГ-ЫН ҮНЭЛГЭЭ, ХУВЬ
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1.ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.		
1	1.1.1.2.Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	0
2	1.1.1.3.Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/	13
3	1.1.1.4.Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	0
4	1.1.1.5.Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	0
5	1.1.2.2.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих	0
6	1.1.2.3.Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
7	1.1.2.4.Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
8	1.1.2.5.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барих	0
9	1.1.2.6.Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шат: Улиастай-Алтай чиглэлийн 42 км авто зам барих	0
10	1.2.1.1.Хилийн боомтуудад ухаалаг цахим гарц суурилуулах	14
11	1.2.1.2.Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтуудыг иж бүрнээр өргөтгөн шинэчлэх	10
12	1.2.1.5.Цагаандэл-Уул хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэх	0
13	1.3.1.2.Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	0
14	1.4.1.2.Гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн давхардлыг арилгах	0
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.		
15	2.1.1.1.Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлэх	0
16	2.1.1.4.Төрөөс бизнесийн үйл ажиллагаанд хийх давхардсан хяналт шалгалтыг бууруулах	0
17	2.1.2.1.Банкны салбарын реформыг хэрэгжүүлж, гадаадын банкны салбар байгуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	0
18	2.1.3.2.Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр шинээр байгуулах	0
19	2.1.3.3.Тайландын Хаант улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс, Бүгд Найрамдах Энэтхэг улсуудтай Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах	0
20	2.2.1.4.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, нэмэгдүүлэх	0

21	2.2.2.1.Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах	0
22	2.2.2.2.Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах	0
23	2.2.3.1.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах	0
24	2.2.3.3.Гангийн үйлдвэр байгуулах	0
25	2.3.2.1.Тавантолгойн 300+150 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	0
26	2.3.2.2.Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөх	0
27	2.3.2.7.Багануурын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	0
28	2.3.2.9. 10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх	0
29	2.3.2.10. 220/110/35кВ-ын Багануур дэд станцыг 220 кВ-аар өргөтгөж, шинэчлэх	0
30	2.3.2.11.Эрдэнэбүрэн-Мянгадын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	0
31	2.3.2.12. Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	0
32	2.3.2.16.Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 МВт-аар өргөтгөх	0
33	2.4.1.2.Монгол кино үйлдвэрийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төв болгох	0
34	2.4.2.1.Байгалийн түүхийн музей /хуучнаар Лениний музей/-г шинэчлэн засварлах	0
35	2.4.2.5.Үндэсний урлагийн их театрын шинэ барилгыг барих	0
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.		
36	3.3.2.1.Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх	25
37	3.3.2.3."Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилга барих	0
38	3.3.2.4.Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих	0
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ.		
39	4.1.1.3.Тусгай бүсийг аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах	0
40	4.1.1.4.Палеонтологийн нөөцөд тулгуурлан "Аялал-Судалгаа-Амралт"-ын цогцолбор байгуулах /Дундговь, Цагаан суварга/	0
41	4.1.1.5.Улирлын чанартай "Буйр нуур" усан замын боомт байгуулах	0
42	4.2.1.2.Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	0
43	4.2.1.3.Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	0
44	4.2.1.4.Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	0
45	4.2.1.5.Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлыг 4С ангилалд нийцүүлэх	0
46	4.3.1.4.Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн А0502 дугаартай 50 км авто замын их засвар хийх /Хэнтий/	0
47	4.3.1.9.Улаангом-Увс нуур чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто зам барих /Увс аймаг/	0
48	4.3.1.10.Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
49	4.3.1.12.Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	0
50	4.3.1.13.Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Хараа голын 85 у/м төмөр бетон гүүр барих	0
51	4.3.1.14.Төв аймгийн Тэрэлж БЦГ-ын (Горхи-0.66 км, Тэрэлж-1.4 км) давааны хатуу хучилттай авто зам барих	0
52	4.3.1.15.Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хооронд 27 км хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэлтийг хийх	0
53	4.3.1.16.Архангай аймгийн Донгойн давааг 2.5 км хатуу хучилттай болгох авто зам барих	0

54	4.3.1.17.Завхан аймгийн Солонготын давааг 11.66 км хатуу хучилттай болгох авто зам барих	0
55	4.3.1.18.Архангай аймгийн Цагаан давааг тойруулан Гурван даваагаар давуулан А0603 дугаартай улсын чанартай авто замтай холбох 32.5 км хатуу хучилттай авто зам барих	0
56	4.3.1.20.Балж голд төмөр бетон гүүр барих	0
57	4.3.1.21.Баруун-Урт- Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/	0
58	4.3.1.22.Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих	0
59	4.3.1.23.Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн бэлэн байдлыг хангах	0
60	4.3.1.24.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих	0
61	4.3.1.25.Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км	0
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5.ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛНА.		
62	5.1.1.2.Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад УТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих	0
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 6.УЛААНБААТАР ХОТЫН ТҮГЖРЭЛ, АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛНА.		
63	6.1.3.6.Цахилгаан автобус цэнэглэх өндөр хүчин чадалтай станц барих;	28
64	6.1.3.4. Нийслэлд тусгай замын автобусны сүлжээ байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /BRT	0
65	6.1.4.2. Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох Наадамчдын гудамжны 800 у/м гүүр барих	0
НИЙТ 65 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ		

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ТӨЛӨВЛӨГӨӨ”-ИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД
ҮНДЭСЛЭН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ БУУРУУЛЖ ҮНЭЛСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Төсөл, арга хэмжээ	ЗГ-ын үнэлгээ	УИХТГ-ын үнэлгээ	Үнэлгээ бууруулсан шалтгаан
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1.ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.				
1	1.1.1.2.Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	30.0	0	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй
2	1.1.1.3.Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/	30.0	13	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй
3	1.1.1.4.Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	30.0	0	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй
4	1.1.1.5.Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	30.0	0	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй
5	1.2.1.1.Хилийн боомтуудад ухаалаг цахим гарц суурилуулах	90.0	14	Хүрсэн түвшингийн талаар буруу тайлагнаж, үнэлсэн
6	1.2.1.2.Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтуудыг иж бүрнээр өргөтгөн шинэчлэх	30.0	10	Хүрсэн түвшингийн талаар буруу тайлагнаж, үнэлсэн
7	1.3.1.1.Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	90.0	50	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.				
8	2.1.1.2.Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гаргасан гомдлыг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх	90	30	Бодит гүйцэтгэл үр дүн 26 хувьтай гарсан.
9	2.1.1.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвөөр дамжуулан түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн бэлэн байдлыг хангуулах	90	30	Төслийн бэлэн байдал хангагдаагүй. Бэлэн байдлыг хангах бэлтгэл ажил эхэлж байгаа
10	2.1.2.2.Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой зөв болгож, биржийн үйл ажиллагааг	80	30	Зах зээлийн хөрвөх чадвар (liquidity) сайжирсан эсэх, Хэрэглэгчдийн худалдан авах чадвар нэмэгдсэн эсэх, Биржийн үйл ажиллагаа

	өргөжүүлж, тогтворжуулах, зах зээлд оролцогчдын эрх ашгийг бүрэн хангах			хэрхэн өргөжсөн, бүртгэлтэй компани нэмэгдсэн эсэх талаар тайлагнаагүй. Бэлтгэл ажил хийгдсэн. Боловсруулалтын шатанд байгаа.
11	2.1.3.1.Бүгд Найрамдах Солонгос Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах	90	30	Хэлэлцээр байгуулагдаагүй. Бэлтгэл ажил хийгдэж байгаа.
12	2.1.3.2.Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр шинээр байгуулах	50	0	Чөлөөт худалдааны хэлэлцээр шинээр байгуулах талаар ажил хийгдээгүй. Үр дүн гараагүй.
13	2.1.3.3.Тайландын Хаант улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс, Бүгд Найрамдах Энэтхэг улсуудтай Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах	30	0	Хэлэлцээр шинээр байгуулах тухай бэлтгэл ажил эхэлсэн. Үр дүн гараагүй.
14	2.2.1.2.Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх	70	30	Өмнөх жилүүдийн судалгааны тайланг нэгтгэх ажил хийгдэж байгаа. 2024 онд судалгааны ажил хийгдээгүй.
15	2.2.1.3.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлэх	50	30	Мэдээллийн санг баяжуулсан хэдий ч цахим систем нэвтэрсэн эсэх, үр дүн гарсан эсэх тодорхойгүй.
16	2.2.1.4.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, нэмэгдүүлэх	30	0	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт хэрхэн хялбаржсан, ямар үр дүн гарсан талаар тодорхойгүй. Зорилтот түвшинд хүрээгүй
17	2.2.2.1.Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах	30	0	2023 онд хийгдсэн ажлыг тайлагнасан. 2024 онд ямар ажил хийгдэж, ямар үр дүнд хүрсэн талаар тодорхойгүй. Орд ашиглалтад ороогүй.
18	2.2.2.2.Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах	30	0	Хармагтай болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хийгдсэн талаар тодорхойгүй. Үр дүн байхгүй
19	2.2.3.1.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах	30	0	Үйлдвэрийн байгуулаагүй. Тооцоо судалгааны ажил эхэлсэн.
20	2.2.3.8."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах	50	30	Дэд бүтэц байгуулах ажил эхэлсэн. Улирлын онцлогоос хамаарч зарим ажил хойшилсон
21	2.2.3.10.Дорноговь аймгийн Хөвсгөл сумын "Гэрэлт говь" кокс, металлургийн үйлдвэр" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах	50	30	Үйлдвэр технологийн парк барих ажил эхэлсэн

22	2.3.1.1.Эрчим хүчний тарифыг индексжүүлж, зохистой түвшинд хүргэх	100	50	Төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд заасан үйл ажиллагааны ашиг, алдагдлын талаар тодорхойгүй. Үр дүн тайлагнаагүй.
23	2.3.2.5.Багахангай /Бөөрөлжүүт/-н 300 МВт-ын дулааны цахилгаан станцын төслийг үргэлжлүүлэх	100	90	Үр дүн гарсан. Зүгшрүүлэх ажил хийгдэж байгаа.
24	2.3.2.9. 10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх	70	0	Төндөр зарлагдсан хэдий ч сонгон шалгаруулалт хийгдсэн эсэх тодорхойгүй. Үр дүн гараагүй.
25	2.3.2.10. 220/110/35кВ-ын Багануур дэд станцыг 220 кВ-аар өргөтгөж, шинэчлэх	100	0	Зам барих тухай тайлагнасан. Дэд станцын талаар тодорхойгүй.
26	2.3.2.17.БНПУ-ын зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг үргэлжлүүлэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс/	70	50	Барилга угсралтын ажлууд 50 хувьтай
27	2.4.2.1.Байгалийн түүхийн музей /хуучнаар Лениний музей/-г шинэчлэн засварлах	30	0	Төсөв батлагдаагүй. Ажил хийгдээгүй.
28	2.4.2.2.Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори байгуулах	75	50	Барилга угсралтын ажил 75 хувьтай. Тодорхой үр дүн гарч эхэлж байгаа.
29	2.5.1.1.Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг үргэлжлүүлэх/Сэлэнгэ, Алтанбулаг/	65	50	2024 онд батлагдсан төсөв хүрээгүй. Гүйцэтгэл 65 хувьтай. 2025 онд барилга угсралтын ажил дуусна.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.				
30	3.1.2.1.Их, дээд сургуулиудын магистр, докторын судалгааны сэдвийг төрийн болон хувийн хэвшилд хэрэгцээтэй байгаа судалгаатай уялдуулах тогтолцоог нэвтрүүлэх	100	70	Хамтарсан судалгааны баг байгуулах хүрээнд зөвхөн ШУТИС нь ЭЗХЯ-тай хамтран гаргасан 105 сэдвийн жагсаалтын талаар тайлагнасан бөгөөд ШУТИС-аас өөр хэдэн сургуульд энэхүү тогтолцоог нэвтрүүлсэн талаарх нэгдсэн тоо байхгүй. Түүнчлэн суурь түвшинг тогтоогоогүйгээс шалтгаалан үр дүн тооцох боломжгүй байна.
31	3.1.3.1.Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах	90	70	Шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл дутуу, хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, үр дүнгийн талаарх мэдээлэл дутуу.
32	3.1.4.6.Үдийн хоол үйлдвэрлэлийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах	100	90	Төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо шаардлага хангасан сургуулийн хувийг 70 хувь хүргэхээр төлөвлөснөөс 65.5 хувьд хүргэсэн. Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувиар үнэлгээ бууруулсан.
33	3.1.4.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд тэгш хамрагдах	100	70	Суралцахуйн түгээмэл загвар бүрдсэн нийт 100 сургууль, цэцэрлэгтэй болохоор төлөвлөснөөс 67 сургууль, цэцэрлэг ийм

	орчин нөхцөлийг бүрдүүлэх			орчин бүрдүүлсэн байна. Тогтоосон шалгуур үзүүлэлтийн тоон утгад нийцүүлэн үнэлгээ бууруулсан.
34	3.2.1.1.Нийгмийн даатгалын шударга тогтолцоонд шилжүүлэх.	90	70	Шалгуур үзүүлэлт тодорхойгүй, шударга тогтолцоонд шилжсэн талаарх үр дүнгийн мэдээлэл дутуу тул үнэлгээ бууруулсан.
35	3.2.3.1.Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	100	90	ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 дахь аргачлалаар үнэлсэн. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа.
36	3.3.1.1.Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах	90	50	Үр дүнгийн үзүүлэлт хэрэгжилтийн хувиас зөрүүтэй. Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн боловч үр дүн тодорхойгүй тул үнэлгээ бууруулсан.
37	3.3.2.1.Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх	30	25	Барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан бөгөөд ажлын гүйцэтгэл 25 хувьтай гэж тайлагнасан. Хүрсэн түвшинг хэмжих мэдээлэл байхгүй тул ажлын гүйцэтгэлийн хувиар үнэлсэн.
38	3.3.2.6.Бүх шатны эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэх /өвчний түүх, эмчилгээний түүх, эмчийн онош, жор/	100	70	Үр дүнгийн үзүүлэлтийг зөрүүтэй, дутуу тайлагнасан.
39	3.3.2.8.Телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагыг нэмэгдүүлэх.	100	90	Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний тоон мэдээлэл зөрүүтэй тул аргачлалын 6.2.2-ын дагуу хэрэгжилтийг үнэлсэн.
40	3.3.3.2.Дотоодын болон олон улсын тэмцээн, наадам зохион байгуулах	90	70	Хүрсэн үр дүнгийн тоо мэдээлэл хэрэгжилтийн тайлангаас зөрүүтэй.
41	3.3.3.3.Биеийн тамир спортын байгууламж, талбай, тоног төхөөрөмжөөр хангах	90	50	Хүрсэн түвшингийн тоон үзүүлэлт зөрүүтэй. Бие бялдрын суурь үзүүлэлт хэрхэн өссөн талаар тайлагнаагүй, хэрэгжилт дутуу.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛНЭ.				
42	4.1.1.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор виз олголтыг хялбаршуулах, визгүй зорчих боломжийг бүрдүүлэх	100	90	6.2.2.1-д зааснаар “гол үр дүн нь гарч эхэлж байгаа”. Тухайлбал, 2024 онд 7 Улстай визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулсан байна.
43	4.1.1.2.Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жуулчид авто машинтайгаа аялах боломжийг бүрдүүлэх	100	70	Салбар хоорондын уялдаа холбоо хангагдаагүй байна. 1/ Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" үр дүнд хүрсэн эсэхийг тусгаагүй. 2/ Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэхэд ЗТХЯ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан боловч ГХЯ, ХЗДХЯ, ЭЗХЯ, ССАЖЗЯ болон холбогдох ТЗТБ хоорондын хамтын ажиллагааны үр дүнг тусгаагүй.

44	4.1.1.3.Тусгай бүсийг аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах	30	0	Хэрэгжилтийг уялдаа холбоогүй тайлагнасан байна. 1/ 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулахад 2,600.0 сая төгрөг батлуулсан бөгөөд 2025 онд дахин сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна. 2/ ЗГҮАХ-ийн 3.2.2.11 болон 3.3.5.12т “ХБ” гэж зөрүүтэй тайлагнасан.
45	4.1.1.5.Улирлын чанартай "Буйр нуур" усан замын боомт байгуулах	30	0	Тухайн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, холбогдох судалгаанд үндэслээгүй. ЗТЯ-аас усан замын боомт байгуулах нөхцөл байдлын судалгааны ажлыг гэрээний дагуу боловсруулж, ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. ГХЯ-аас “усан замын боомт” байгуулахгүйгээр зэргэлдээх авто замын боомтын дэд бүтцийг сайжруулж, хил орчмын маршрутыг гаргах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой талаар танилцуулга бэлтгэжээ.
46	4.2.1.1.Агаарын тээврийн либералчлалыг бүрэн хэрэгжүүлэх	90	50	Хэрэгжилтийг дутуу тайлагнасан байна. ЗГҮАХ-ийн 3.3.2.14-т тусгасан бөгөөд ЗГ, УИХТГ 50% үнэлсэн. ЗГҮАХ-т мэдээллийг нэмэлтээр тусгасан байна.
47	4.2.1.2.Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	30	0	Хэрэгжилтийг дутуу тайлагнасан байна. ЗГҮАХ-ийн 2024 оны тайлангийн 3.3.2.11-д нэмэлт мэдээлэл тусгасан байна.
48	4.2.1.3.Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	30	0	Хэрэгжилтийг дутуу тайлагнасан байна. ЗГҮАХ-ийн 2024 оны тайлангийн 3.3.2.11-д нэмэлт мэдээлэл тусгасан байна.
49	4.2.1.4.Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах	30	0	Хэрэгжилтийг дутуу тайлагнасан байна. ЗГҮАХ-ийн 2024 оны тайлангийн 3.3.2.11-д нэмэлт мэдээлэл тусгасан байна.
50	4.2.1.5.Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлыг 4С ангилалд нийцүүлэх	30	0	Хэрэгжилтийг дутуу тайлагнасан байна. ЗГҮАХ-ийн 2024 оны тайлангийн 3.3.2.11-д нэмэлт мэдээлэл тусгасан байна.
51	4.3.1.1.Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам барих /Дорнод, Баян-Уул сум/	60	30	тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа
52	4.3.1.2.Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто зам барих /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/	70	30	тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа

53	4.3.1.3.Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай 130 км авто замыг үргэлжлүүлэх /Хэнтий, Батноров, Норовлин сум/	90	70	Багц-2 авто замын ажил 75%-ийн гүйцэтгэлтэй байна.
54	4.3.1.4.Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн А0502 дугаартай 50 км авто замын их засвар хийх /Хэнтий/	30	0	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан.
55	4.3.1.5.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам барих /Дорнод/	50	30	Ажлын гүйцэтгэл дунджаар 31.4 хувьтай байна.
56	4.3.1.7.Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км	100	50	43,677.10 төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 6,664.60 төгрөгийн гүйцэтгэлтэй тул "ажил тодорхой хэмжээнд эхэлсэн" гэж үнэлсэн.
57	4.3.1.8.Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/	100	90	гол үр дүн нь гарч эхэлж байгаа
58	4.3.1.9.Улаангом-Увс нуур чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто зам барих /Увс аймаг/	30	0	бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа
59	4.3.1.10.Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	30	0	бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа
60	4.3.1.11.Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100-200 км тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах /амрах өртөө/.	70	50	Байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажилласан үр дүнг тайланг тусгаагүй. 1/Гүйцэтгэлийн санхүүжилтийг тайланд тусгаагүй. 2/ЗТЯ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгаж, ССАЖЗЯ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгаагүй байна. Тухайлбал, ЗГҮАХХТ-ын 3.3.5.7.Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна" гэсэн зорилтын хүрээнд "ССАЖЗС-ын багцад 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлын хүрээнд нийт 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 10.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 ТАХ батлагдаж, 9.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон" гэж тайлагнаж, үр дүнг тусгаагүй. Иймд гүйцэтгэлийг 50%-ажил тодорхой хэмжээнд эхэлсэн" гэж тооцсон.
61	4.3.1.12.Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх	30	0	бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа. зураг төслийг боловсруулж дууссан. Барилгын ажлын санхүүжилт шийдэгдээгүй.

62	4.3.1.13.Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Хараа голын 85 у/м төмөр бетон гүүр барих	30	0	худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажил хангагдаж байна.
63	4.3.1.14.Төв аймгийн Тэрэлж БЦГ-ын (Горхи-0.66 км, Тэрэлж-1.4 км) давааны хатуу хучилттай авто зам барих	30	0	Санхүүжилт батлагдсан боловч ямар нэгэн ажил зохион байгуулаагүй шалтгаан нөхцөлийг тайланд тусгаагүй.
64	4.3.1.15.Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хооронд 27 км хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэлтийг хийх	30	0	бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа
65	4.3.1.16.Архангай аймгийн Донгойн давааг 2.5 км хатуу хучилттай болгох авто зам барих	30	0	Замын трассын асуудлыг ШУТЗ-ийн хуралдаанд дахин танилцуулахаар болсон.
66	4.3.1.17.Завхан аймгийн Солонготын давааг 11.66 км хатуу хучилттай болгох авто зам барих	30	0	зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн
67	4.3.1.18.Архангай аймгийн Цагаан давааг тойруулан Гурван даваагаар давуулан А0603 дугаартай улсын чанартай авто замтай холбох 32.5 км хатуу хучилттай авто зам барих	30	0	зураг төслийг боловсруулж байна.
68	4.3.1.20.Балж голд төмөр бетон гүүр барих	30	0	санхүүжилт шийдвэрлэгдээгүй.
69	4.3.1.21.Баруун-Урт- Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/	20	0	ЗГҮАХХТ-ын 4.3.1.21-д "Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалт 2025 оны Улсын төсөвт тусгагдсан. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулна."
70	4.3.1.22.Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих	20	0	1/ Батлагдсан төсвийн 17.5%-ийн зарцуулалттай, авто замын багц-1 Барилгын ажил 13%-тай. Багц-2 024 оны Улсын төсөвт туссан хөрөнгийн хэмжээнд ажил бүрэн хийгдсэн. 2/ЗГҮАХХТ-ын 3.3.2.16-д заасан "Замын-Үүд-Алтанбулаг болон Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөж, Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам, Улаанбаатар-Лүн чиглэлийн 6 эгнээ авто замын төслийг эхлүүлж, Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулна" гэсэн зорилтын хүрээнд "... Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн авто замтай нийлэх 2 түвшний уулзвар барих" ажлын барилгын ажлыг эхлүүлсэн ..." гэж тусгажээ.
71	4.3.1.23.Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн бэлэн байдлыг хангах	30	0	1/ Салбарын ШУТЗ-ийн 2024.12.20-ны хуралдаанаар Арвайхээр - Даланзадгад чиглэлийн авто замын ТЭЗҮ, трассын талаар танилцуулга хийсэн, трассын судалгааг дахин оруулж ирэхээр буцаасан. 2/ЗГҮАХХТ-ын 3.3.2.16-д заасан "Замын-Үүд-Алтанбулаг

				болон Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөж, Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам, Улаанбаатар-Лүн чиглэлийн 6 эгнээ авто замын төслийг эхлүүлж, Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулна" гэсэн зорилтын хүрээнд "Арвайхээр – Мандалговь чиглэлийн 2.61 км авто зам болон Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн авто замтай нийлэх 2 түвшний уулзвар барих" ажлын барилгын ажлыг эхлүүлсэн.
72	4.3.1.24.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих	30	0	барилгын ажлын гүйцэтгэх гэрээ байгуулахаар хүлээгдэж байна. ЗГҮАХХТ-ын 1.3.3.6-д "... 2024.11.17-нд гэрээ байгуулах эрх олгогдсон. Тус авто замын үлдсэн хэсгийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр банктай хамтран урьдчилсан судалгааг хийж байна" гэж тайлагнажээ.
73	4.3.1.25.Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км	30	0	Барилга угсралтын ажил 15.52 хувьтай хэрэгжиж байна.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 7.3.АСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ				
74	7.1.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	100	70	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн дагуу тайлагнаагүй, тухайлбал, тус арга хэмжээ хэрэгжсэнээр гарсан үр дүн тодорхойгүй. Хөтөлбөр батлуулсан хэдий ч үр дүнг тайлагнаагүйгээс гадна авлигын индекс, авлигын гэмт хэрэг буурсан эсэх тухайд тодорхой тайлагнаагүй байна. Тухайлбал, ҮСХ-ноос гаргасан Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх статистик мэдээллээс харахад 2020 оноос хойш авлигын гэмт хэргийн тоо, түүн дотроо эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн тоо тасралтгүй өссөн байна.
75	7.1.1.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох	100	90	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн дагуу тайлагнаагүй, гарсан үр дүн тодорхойгүй. Тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хийгдсэн ажлын талаар тайлагнаагүй.
76	7.2.1.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх	100	70	Тус арга хэмжээний хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй буюу тодорхой бус, мэдээлэл хангалтгүй байна. Журамд заасны дагуу гарсан үр дүнг товч, тодорхой, нотлогдохуйц байдлаар тайлагнах.
77	7.2.4.1.Газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх	70	30	Тус ажлын хүрээнд асуудал тодорхойлох судалгаа хийж, ТЭЗҮ-ийг боловсруулж, 2024 оны улсын төсвийн санхүүжилтээр хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар ажилласан боловч 2024 оны улсын төсөвт тусгагдаагүй, санхүүгийн асуудал шийдвэрлэгдээгүй байгаа тус ажлыг хийх бэлтгэл шатны ажил хийгдэж байгаа тул үнэлгээг бууруулан үнэллээ.

78	7.2.4.2.Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх	70	30	“Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын ТЭЗҮ-г боловсруулж 2021 онд Барилга хот, байгуулалтын яамны төрийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд тухайн ажлын санхүүжилт нь улсын төсөвт суугаагүй тул тодорхой ажил хийгдээгүй гэж тайлагнасан боловч аргачлалд заасны дагуу үнэлээгүй байх тул аргачлалд нийцүүлэн үнэлгээг бууруулсан.
79	7.4.1.1.“Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулах	90	70	Оюутан цэргийн мэргэжил олгох сургалтад 2000 оюутан хамруулахаар 2024 оны зорилтот түвшинг төлөвлөсөн боловч төсөв батлагдаагүй тул хуваарилсан төсвийн дагуу 1030 оюутан хамруулсан байна. иймд зорилтот түвшинг бүрэн хангаагүй тул үнэлгээг бууруулах үндэслэл болсон. Хэрэгжилт: 2024 онд 1,500 оюутан, суралцагч хамруулахаар 3,4 тэрбум төгрөгийн төсвийн төсөөллийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2,1 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан нь 1000 гаруй оюутан, суралцагч хамруулах боломжтой болсон. Ингэснээр Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/35 дугаар тушаалаар “Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт”-д 2024 онд 1030 оюутан, суралцагчийг хамруулахаар шийдвэрлэсэн.
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 8.НОГООН ХӨГЖЛИЙН ДЭМЖИХ				
80	8.1.1.1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	90	70	Мэдээлэл хангалтгүй буюу хэрэгжилтийг дутуу тайлагнасан. Шаталсан ойн талбайн бууралтын талаар хийгдсэн ажил, гарсан үр дүнгийн талаар тайланд тусгаагүй.

---oOo---